



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 21 он 07 дугаар
сарын 08-ны өдөр

Дугаар ХЭГ/955

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Б.БАЯРСАЙХАН ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн Загастайн давааны 67 км хатуу хучилттай авто замын ажлын явц болон түүнтэй холбоотой асуудлын талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Танд хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт: 2 хуудастай.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Ц.НЯМДОРЖ

000021505683

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
2021 оны 4 дугаар сарын 28 -ны өдрийн
ХМ/955 дугаар албан бичгийн хавсралт

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Б.БАЯРСАЙХАНААС МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДАД ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ

Асуулга. Завхан аймгийн Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км авто замын төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын явц болон хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг 2021 оны хэддүгээр сард эхлүүлж, хэдэн сард ашиглалтад оруулахаар төлөвлөж байгаа талаар тодорхой хариултыг ирүүлнэ үү.

Манай улсын 112,414.2 километр авто замын сүлжээний 14.918 километр нь олон улс, улсын чанартай авто замын сүлжээнд хамаарч, тус сүлжээний 50 хувь нь хатуу хучилттай замаар ашиглагдаж, нийт ачаа тээвэрлэлтийн 60.5, зорчигч тээвэрлэлтийн 75 хувийг автотээврээр гүйцэтгэж байна.

Монгол Улсын Засгийн газраас эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн авто замын сүлжээг бий болгох зорилтын хүрээнд өнгөрсөн 4 жилийн хугацаанд нийт 2102.5 км хатуу хучилттай авто зам, 2727.0 у/м төмөрбетон гүүрийг барьж ашиглалтад оруулсан бөгөөд үүний үр дүнд нийт 20 аймгийн төв, 106 сум, 5 хилийн боомт хатуу хучилттай авто замаар нийслэлтэй холбогдоод байна.

Холбогдоогүй үлдэж буй Завхан аймгийн төвийг 2021 онд нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбохоор зорилт тавин ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан бүх аймгийн төвүүдийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбож дуусгах зорилтын хүрээнд Засгийн газрын 2017 оны 132 дугаар тогтоолоор Завхан аймгийн төвийг нийслэл хоттой холбох Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км хатуу хучилттай авто замын төслийг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт олгосон 500.0 сая ам долларын экспортын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд энэхүү төслийн барилгын ажлын гүйцэтгэгчээр “Чайна Коммуникэйшн Констракшн” ХХК шалгарч 2018 оны 3 дугаар сарын 12-ны өдөр Зам, тээврийн хөгжлийн яамтай 20.9 сая ам долларын төсөвт өртөгтэй гэрээг байгуулсан ба хяналтын зөвлөх үйлчилгээний санхүүжилттэй холбоотойгоор барилга угсралтын ажлыг 2019 оны 6 дугаар сард эхлүүлсэн.

Барилгын ажлын талбайд өнгөрсөн жил газар шорооны ажил 98%, суурийн ажил 70%, асфальтбетон хучилтын ажил 68%, хиймэл байгууламж буюу төмөрбетон хоолойн ажил 85%, Загастайн голын гүүрийн ажил 95.0%, Хатавчийн голын гүүрийн ажил 93.0%-тай хийгдсэн бөгөөд энэхүү авто замын барилгын ажлын гүйцэтгэл 76.5%-тай байна. Тосонцэнгэл-Улиастай Чиглэлийн 67 км авто замын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн нээсэн бөгөөд үүнээс 40 км авто зам нь асфальтбетон хучилтаар, 24 км авто зам нь хайрган шороон замаар авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг нэвтрүүлж байна.

Тухайн төслийн гүйцэтгэгч компани барилгын угсралтын ажлыг 2021 оны

4 дүгээр сарын 15-ны өдөр эхлүүлэхээр төлөвлөн бэлтгэл ажлыг ханган ажиллаж байгаа бөгөөд энэ онд үлдсэн 24 км авто замын газар шорооны ажил болон цементээр бэхжүүлсэн суурь, асфальтбетон хучилт, нийт авто замын тоноглол, тэмдэглэгээ, нөхөн сэргээлт, заслын ажлыг хийж гүйцэтгэх ба энэхүү авто замын барилгын ажлыг 2021 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор дуусгаж, ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна.

Энэхүү авто замын барилгын ажлын өмнөх гүйцэтгэгчийн гэрээг 2016 онд дуусгавар болгож, төслийн үлдэгдэл буюу тендер зарлах үеийн ажлын тоо хэмжээг 2017 онд тодорхойлсноос хойш барилгын ажил эхлэх 2019 оныг хүртэлх хугацаанд байгаль цаг уур болон бусад хүчин зүйлээс хамаарч Зам, тээврийн хөгжлийн яамтай байгуулсан гэрээний ажлын тоо хэмжээнд өөрчлөлт орсонтой холбоотойгоор захиалагчийн зүгээс зураг зохиогч “Эм Си Пи Си Жи Ар” ХХК-аар зураг төслийг дахин хийлгэж, 2019 оны 7 дугаар сарын 26-ны өдөр магадлалын ерөнхий дүгнэлтийг гаргуулан баталгаажуулсан. Уг магадлалын ерөнхий дүгнэлтээр тухайн зам барилгын ажлын төсөвт өртөг буюу гэрээний үнийн дүн 2.4 сая ам.доллар буюу 6.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд энэхүү нэмэлт санхүүжилт Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуульд тусгагдсан.

Завхан аймгийн төвийг нийслэл хоттой холбох Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км авто зам нь Завхан аймаг дахь Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн авто замын хамгийн хүнд, бэрхшээлтэй нөхцөлд тооцогдох Монгол орны Тарвагатайн нурууны хүндрэлтэй даваа болох Загастайн давааг дайран өнгөрдөг уулын авто зам бөгөөд зам барилгын ажил үргэлжлэх хугацаа богино, эрс тэс уур амьсгалтай манай орны хувьд үлдэж буй богино хугацаанд тухайн төслийг үр дүнтэй зохион байгуулж, гэрээт хугацаанд нь ашиглалтад оруулах зорилгоор Зам, тээврийн хөгжлийн яамнаас дээрх төслийн гүйцэтгэгч болох “Чайна Коммуникэйшн Констракшн” ХХК-тай шууд гэрээ байгуулж, гүйцэтгүүлэх нь хууль, эрх зүйн хувьд боломжтой эсэх талаар холбогдох чиглэл ирүүлэх хүсэлтийг Сангийн яаманд 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 01/6149 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Сангийн яамнаас 2020 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 6-1/172 тоот албан бичгээр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4-д “нэмэлт ажлын өртөг нь анхны гэрээний үнийн 15 хувь болон энэ хуулийн 8.1.1-д заасан харьцуулалтын босго үнийн аль багаас хэтрээгүй нөхцөлд” гэж заасны дагуу гэрээ шууд байгуулах боломжгүй гэсэн чиглэлийг Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн.

Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан “Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-д Зам, тээврийн хөгжлийн сайдын багцад тусгагдсан “Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн Загастайн давааны 67 км хатуу хучилттай авто замын дуусгал /Завхан/” төсөлд хуваарилагдсан 6.1 тэрбум төгрөгийн ажилд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд нээлттэй тендер шалгаруулалтыг 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдөр зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж байна.

Энэхүү авто замыг ашиглалтад оруулснаар Завхан аймгийн төв Улиастай хот болон бүх аймгийн төв нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбогдож, ард иргэд тав тухтай, түргэн шуурхай зорчих боломж бүрдэхийн зэрэгцээ Завхан аймгийг зорин очих гадаад болон дотоодын жуулчдын тоо нэмэгдэж, цаашлаад тухайн бүс нутгийн эдийн засгийн өсөлтийг дэмжих авто зам болно.